



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

“Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын
Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өсвөр үе хүнс” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг байгууллагын нийт ажилтнуудад, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан (Ш.Сэргэлэн)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан тус байгууллагын захирлын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.



ЗАХИРАЛ

Г.МӨНХЗУЛ

3130600049